

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

2019 онд байгуулагдсан ажлын хэсгүүдийн үүрэг
даалгаврын биелэлт тайлангийн тухай

2020.01.13

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын тушаалаар 2019 онд байгуулагдсан нийт ажлын хэсгүүдийг үүрэг, даалгаварын биелэлт, тайланд нэгтгэлээ. Тус онд нийт 22 ажлын хэсэг, комисс томилогдсон ба эдгээрээс байнгын үйл ажиллагаатай 4, түр зуурын шинжтэй 16 байна.

Байнгын шинжтэй:

1. Биеийн тамир, спортын хамтлаг
2. Ёс зүйн зөвлөл
3. Техникийн комисс
4. Үнэлгээний хороо

Түр зуурын шинжтэй:




График 1. Түр зуурын шинжтэй ажлын хэсгүүдийн тоо

Хүснэгт 1.

№	Тушаал-ын №	Ажлын хэсэг	Тайлан
1	A/15	БТСХамтлаг	Тус хамтлаг нь 2019 онд дараах томоохон ажлуудыг зохион байгуулсан. “Дасгал хөдөлгөөн-Эрүүл аж төрөхүй” сэдэвт сургалт, Ажилтан, албан хаагчдын бие бялдарын түвшин тогтоох сорил, Байгууллагын аварга шалгаруулах спортын 4 төрөлт тэмцээн, Марафон-2019 олон улсын гүйлтийн тэмцээнд ННҮГ-ын албан хаагчдыг зохион байгуулсан ба ЗСХ-ийн албан хаагчдын дунд илүүдэл жингээ хаяцагаая, нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын дунд спортын 3 төрөлт тэмцээнийн тус тус амжилттай

			зохион байгуулж, тайланг хагас бүтэн жилээр гаргаж ажилласан.
2	A/20	Ёс зүйн зөвлөл	Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 7 удаа хуралдаж, 1 ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1, 1 ажилтанд мөн хуулийн 131.1.2, 7 ажилтанд мөн хуулийн 131.1.3-д зааснаар тус тус сахилгын шийтгэл ногдуулж, 3 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзэж, хурлын тэмдэглэлээр сануулга өгч ажилласан.
3	A/39	Техникийн комисс	Цахилгааны 145, холбоо, дохиолол, сүлжээний 20, сантехникийн 62, нийт 227 техникийн комиссын акт үйлдсэн байна.
4	A/47	Үнэлгээний хороо	Зоогийн газрын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хүнсний материал, цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэх цэвэрлэгээний материал тус тус худалдан авахад 12, НЗЗ-ны байруудын засвартай холбоотой 2, нийт 14 төрлийн худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвлөмжийг удирдлагад хүргүүлж ажилласан.
5	A/09	Стандартууд боловсруулах	Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх “Хоол цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий стандарт”, “Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий стандарт”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий стандарт”-ыг тус тус боловсруулж, ННҮГ-ын даргын 2019 оны А/18 тушаалаар батлуулсан.
6	A/13	ХНХөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Ажлын хэсэг 2018-2020 онд хэрэгжүүлэх Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн дагуу 2019 онд хэрэгжүүлэх, сургалт, мэдээллийн цагийн төлөвлөгөөг гарган батлуулж, хуваарийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, хагас бүтэн жилээр тайлагнасан.
7	A..	Ур чадвар дүгнэх	ННҮГ-ын ажилтан, албан хаагчдын ур чадварыг улирал тутам дүгнэж, дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлж ажилласан.
8	A/36	Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх	Нийт 44 заалт бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан ба Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан улсын үзлэг явуулах хуваарийн дагуу ажлын хэсэг тус газарт 2019 оны 09 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд улсын үзлэгийг зохион байгуулсан. Үзлэгийн нэгдсэн дүнгээр манай байгууллага 94 хувь А буюу “Бүрэн хангалттай” үнэлэгдсэн.
9	A/54	Баянхошуу дэд төвийг хүлээн авах	Тус төвийн барилгыг 8 дугаар сард хүлээлгэж өгөхөөр гүйцэтгэгч компанийн ирүүлсэн хүсэлтийн дагуу ажлын хэсэг ажиллаж зөвлөмж, шаардлагыг 3 удаа өгч, хэрэгжилтийг хангуулан 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан.
10	A/70	Хөргүүртэй ачааны автомашин хүлээн авах	Хөргүүртэй ачааны автомашиныг хүлээж авахдаа бичиг баримтын бүрдлийг зураг бусад зүйлстэй тулгалт хийж, ӨАУГ-аас холбогдох материалыг бүрдүүлэн 2019 оны 07 дугаар сард хүлээж авсан.
11	A/73	ЗСХ-ийн албан хаагчдийн үр дүнг	Ажлын үр дүнг дүгнүүлэх 45 албан хаагчаас 40 албан хаагчийн ажлыг дүгнэж, 1 албан хаагч чөлөөтэй

		үнэлэх	шалтгаанаар дүгнэгдээгүй ба 4 албан хаагчийг газрын дарга дүгнэнэ. Ажлын хэсэг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр НЗЗ-ны 2 дугаар байр буюу Хангарди ордны хурлын зааланд 15:00 цагаас албан хаагчдын тайланг хамгаалуулж, холбогдох журмын “Үр дүнг үнэлэх хуудас”-ын шалгуур үзүүлэлтийн дагуу оноогоор үнэлсэн. Үнэлэгдсэн албан хаагчдад тухай бүр нь үнэлгээг танилцуулж ажилласан ба ямар нэгэн гомдол санал гараагүй. Үр дүнг дүгнүүлсэн албан хаагчдаас А үнэлгээтэй 18, В үнэлгээтэй 17, С үнэлгээтэй 4 албан хаагч тус тус байна.
	В ...	Албан хаагчдын ажлыг хүлээлцэх тухай	Тайлант хугацаанд нийт ажил хүлээлцэх 50 тушаал гарч, НЗД-ын А/633-р захирамжаар батлагдсан маягтын дагуу ажил хүлээлцүүлж, тухайн албан хаагчдын ажилласан хугацааны тайлан, төлөвлөгөөний биелэлтийг гаргуулан, холбогдох тооцоог хийж хүлээлцсэн.

Газрын даргын тушаал байгуулагдсан ажлын хэсгүүд 2019 онд үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж ажиллалаа.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ